Бараа материалын үлдэгдэл урьд оноос 53317.9 мянган төгрөг буюу 19.9 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| № | Байгууллагуудын нэрс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ИТХ | 5,588.5 | 6,746.7 | 1,158.3 | 2.1 |
| 2 | ЗДТГ | 44,911.7 | 61,774.5 | 16,862.8 | 19.2 |
| 3 | Сургууль | 87,477.3 | 97,124.7 | 9,647.4 | 30.2 |
| 4 | ЭМТ | 72,135.9 | 82,898.0 | 10,762.1 | 25.8 |
| 5 | Цэцэрлэг | 51,224.7 | 65,952.1 | 14,727.3 | 20.5 |
| 6 | Соёлын төв | 7,104.3 | 7,264.3 | 160.0 | 2.3 |
| | **Салбарын нийт дүн** | **268,442.4** | **321,760.3** | **53,317.9** | **100.0** |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 247608.9 мянган төгрөгийн бараа материалын 227387.1 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 11130.7 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| **Нэмэгдсэн** | **247,608.9** | **Хасагдсан** | **194,291.0** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 227,387.1 | Худалдсан, зарцуулсан | 194,291.0 |
| Хандиваар | - | Шилжүүлсэн | - |
| Шилжүүлэн авсан | 11,130.7 | Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр | - |
| Бусад | 9,091.1 | Бусад | - |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6454563.6 мянга, эцсийн үлдэгдэл 6851081.8 мянган төгрөг болж, 396518.2 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | **6,365,425.6** | **6,761,788.3** | **396,362.7** | **98.7** |
| Барилга байгууламж, орон сууц | 5,382,275.0 | 5,697,101.1 | 314,826.1 | 83.2 |
| Тээврийн хэсэгсэл | 191,939.2 | 223,439.2 | 31,500.0 | 3.3 |
| Машин тоног төхөөрөмж | 507,316.3 | 556,500.0 | 49,183.7 | 8.1 |
| Тавилга эд хогшил | 245,574.8 | 263,723.8 | 18,149.0 | 3.8 |
| Номын фонд | 35,320.3 | 18,024.2 | (17,296.1) | 0.3 |
| Бусад үндсэн хөрөнгө | 3,000.0 | 3,000.0 | - | 0.0 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | **89,138.0** | **89,293.5** | **155.5** | **1.3** |
| Програм хангамж | 1,580.0 | 1,735.5 | 155.5 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 87,558.0 | 87,558.0 | - | 1.3 |
| | **6,454,563.6** | **6,851,081.8** | **396,518.2** | **100.0** |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 464946.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 56304.7 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн худалдан авалтаар, 41993.4 мянган төгрөгийг шилжүүлсэн авч, бусад үндсэн хөрөнгө хэсэгт ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд 216737.3 мянган төгрөгийн өртөг бүхий 1-р багийн хүүхдийн хөгжлийн төв, 98088.8 мянган төгрөгийн өртөг

бүхий 4-р багийн төвийн барилга, 13000.0 мянган төгрөгийн ЦДАШ болон гудамжны гэрэлтүүлэг зэргийг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| № | Байгууллагуудын нэрс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ИТХ | 3,940.0 | 13,089.0 | 9,149.0 | 0.2 |
| 2 | ЗДТГ | 2,664,491.3 | 2,985,093.9 | 320,602.6 | 43.6 |
| 3 | Сургууль | 1,900,542.3 | 1,880,815.4 | (19,726.9) | 27.5 |
| 4 | ЭМТ | 484,950.2 | 532,669.2 | 47,718.9 | 7.8 |
| 5 | Цэцэрлэг | 1,038,865.4 | 1,047,481.4 | 8,616.0 | 15.3 |
| 6 | Соёлын төв | 361,774.4 | 391,932.9 | 30,158.5 | 5.7 |
| | **Салбарын нийт дүн** | **6,454,563.6** | **6,851,081.8** | **396,518.2** | **100.0** |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт 68428.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

*Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| **Нэмэгдсэн** | **464,946.9** | **Хасагдсан** | **68,428.7** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 56,304.7 | Худалдсан | - |
| Хандиваар | - | Акталсан | 68,428.7 |
| Шилжүүлэн авсан | 41,993.4 | Шилжүүлсэн | - |
| Бусад | 366,648.7 | Бусад | - |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2043.1 мянга, эцсийн үлдэгдэл 25843.7 мянган төгрөг болж 23800.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН** | **2,043.1** | **25,843.7** | **23,800.6** | **100.0** |
| 4131 | **Ажилчидтай холбогдсон өглөг** | - | 9,445.3 | 9,445.3 | 36.5 |
| 4132 | **Бараа үйлчилгээний зардлын өглөг** | 1,362.8 | 14,095.8 | 12,733.0 | 54.5 |
| 41361 | **Байгууллагад төлөх өглөг** | 680.3 | 2,109.9 | 1,429.6 | 8.2 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 192.8 | 192.8 | 0.7 |
| | Дүн | 2,043.1 | 25,843.7 | 23,800.6 | 100.0 |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 9445.3 мянган төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг, 14095.8 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлын байгууллагад төлөх өглөг, 2109.9 мянган төгрөгийн байгууллагад өгөх өглөг, 192.8 мянган төгрөгийн хувь хүмүүст өгөх өглөг байна. Үүнээс Эрүүл мэндийн төвийн 12723.6 мянгөн төгрөгийн эмийн өглөг, Ерөнхий боловсролын сургуулийн НДШ-ийн өглөг 7238.4 мянган төгрөг байгаа нь голлон нөлөөлсөн байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Д.д | Байгууллагуудын нэр | Өглөгийн эхний үлдэгдэл | Өглөгийн эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ИТХ | - | 11.0 | 11.0 | 0.0 |
| 2 | ЗДТГ | - | 166.8 | 166.8 | 0.6 |
| 3 | Сургууль | - | 7,762.4 | 7,762.4 | 30.0 |
| 4 | ЭМТ | - | 15,569.4 | 15,569.4 | 60.2 |
| 5 | Цэцэрлэг | 2,043.1 | 2,074.2 | 31.1 | 8.0 |
| 6 | Соёлын төв | - | 259.9 | 259.9 | 1.0 |
| | **ТШЗ-ийн байгууллагын ДҮН** | **2,043.1** | **25,843.7** | **23,800.6** | **100.0** |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 802683.3 мянга, эцсийн үлдэгдэл 919702.8 мянган төгрөг болж, 117019.5 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,979,603.61 | 6,170,647.34 | 191,043.7 | |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,588,966.5 | 1,588,966.5 | - | 25.8 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,588,966.5 | 1,588,966.5 | - | 25.8 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,226,191.9 | 2,417,465.6 | 191,273.7 | 39.2 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,164,445.2 | 2,164,215.2 | (230.0) | 35.1 |
| **6** | **Дүн** | **5,979,603.6** | **6,170,647.3** | 191,043.7 | 100.0 |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6170647.3 мянган төгрөг болж 191043.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 191273.7 мянган төгрөгийн өсөлт, дахин үнэлгээ дансны 230.0 мянган төгрөгийн бууралттай холбоотой байна.

### 3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.13-ны өдрийн хуралдаанаар 11/05 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 41260.0 мянга, хүү торгуулийн орлогыг 1500.0 мянга, нийт 42760.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.09.25-ны өдрийн 13/01 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1000.0 мянган төгрөгөөр нэмж тодотгон татварын орлогыг 42260.0 мянга, хүү торгуулийн орлогыг 1500.0 мянга, өөрийн орлогыг 1000.0 мянган төгрөгөөр баталжээ.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Дд | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Сумд төвлөрөх орлогын дүн** | **42,260.0** | **68,229.8** | **27,394.8** | **161.5** |
| 1 | ИОТХ | 5,000.0 | 36,086.7 | 31,086.7 | 721.7 |
| 2 | хадгаламжийн хүүгийн орлого | 21,000.0 | 22,953.6 | 1,953.6 | 109.3 |
| 3 | ҮХЭХ борлуулсны албан татвар | | 2,718.3 | 2,718.3 | - |
| 4 | Бууны татвар | 4,000.0 | 2,794.0 | (1,206.0) | 69.9 |
| 5 | Улсын тэмдэгт | 2,500.0 | 1,437.5 | (1,062.5) | 57.5 |
| 6 | Газрын төлбөр | 1,560.0 | 1,020.8 | (539.2) | 65.4 |
| 7 | Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,000.0 | 443.9 | (5,556.1) | 7.4 |
| 8 | ТТАМАТөлбөр | 2,200.0 | 775.0 | - | - |
| | **Татварын бус орлого** | **1,500.0** | **2,184.7** | **684.7** | **145.6** |
| 10 | Хүү торгууль | 1,500.0 | 2,184.7 | 684.7 | 145.6 |
| | **Дүн** | **43,760.0** | **70,414.5** | **28,079.5** | **160.9** |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын 2020 оны ИТХ-ын тогтоол, татварын орлогын мэдээ*

Сумын төсөвт төвлөрөх бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас бусад татварын орлогыг 28079.5 мянган төгрөгөөр буюу 160.5 хувиар давуулан биелүүлсэн байна. ИОТХ-ын орлого нь давсан шалтгаан нь 2020 оны 12 дугаар сард "Эрдэнэс таван толгой" ХК-ны ногдол ашгийн орлогын суутган татвараас шалтгаалсан байна.

Сумын ИТХ-ын 2019.12.13-ны өдрийн хуралдаанаар 11/05 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр ЗДТГ 2000.0 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 63333.4 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 49492.3 мянган төгрөгийн орлогыг оруулсан бол ОНХС-д туслах үйл ажиллагааны орлогоор 2970.0 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2556022.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2391551.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2219298.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 172253.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

## 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсөв батлах тухай 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолд заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 2650.0 мянга, аймгийн төсөвт 94240.0 мянга, нийт 96890.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 109922.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.5 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт №14. Улс, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Ґ ё° âлегөө | Ã¿éóýðгэл | Зөрүү | Õóâü |
|---|---|---|---|---|
| **А. Улсын төсөв** | **2,650.0** | **3,277.7** | **627.7** | **123.7** |
| 1. ÀÀÍ Á-í î õëî ãû í òàòâàð | 1,300.0 | 948.4 | (351.6) | 73.0 |
| 2. Í • ÀÕàòâàð | 550.0 | 326.0 | (224.0) | 59.3 |
| 4. Агаарын бохирдол/авто/ | 800.0 | 2,003.3 | 1,203.3 | 250.4 |
| **В.Аймгийн төсөв /712/** | **94,240.0** | **106,644.7** | **12,404.7** | **113.2** |
| 1.ÕÓÒÀ î õëî ã /Ñóóòãàí -1/ | 75,000.0 | 82,816.6 | 7,816.6 | 110.4 |
| 2. ÀÓ ßÕ-í òàòâàð | 14,300.0 | 19,725.3 | 5,425.3 | 137.9 |
| 3. ÏХЭХ-ийн татвар | 2,600.0 | 3,061.0 | 461.0 | 117.7 |
| 4. Газрын төлбөр | 2,340.0 | 1,041.8 | (1,298.2) | 44.5 |
| **Дүн** | **96,890.0** | **109,922.4** | **13,032.4** | **113.5** |

### Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 8 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2019.12.13-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор нийт 2692315.0 мянган төгрөгийг баталсан байна.

*Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төсвийн төсөл | Анх батлагдсан | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 56,182.1 | 87,799.5 | 31,617.4 |
| Засаг даргын Тамгын газар | 368,210.7 | 444,284.7 | 76,074.0 |
| Сургууль | 934,211.9 | 853,207.0 | (81,004.9) |
| Цэцэрлэг | 362,447.7 | 326,424.1 | (36,023.6) |
| Эрүүл мэндийн төв | | 446,393.8 | 446,393.8 |
| Соёлын төв | 169,367.4 | 180,454.6 | 11,087.2 |
| Сум хөгжүүлэх сан | | 93,333.4 | 93,333.4 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 187,279.5 | 187,279.5 |
| Дүн | 1,890,419.7 | 2,619,176.6 | 728,756.9 |

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.13-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор анх баталсан 2692315.0 мянган төгрөгийг 2020.09.25-ны өдрийн 13/01 дугаар тогтоолоор 72138.4 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.10.27-ны өдрийн А/701 дугаар захирамжаар 11938.7 мянган төгрөгийн нэмэгдүүлж, 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 75092.5 мянган төгрөгийг бууруулснаар сумын нийт төсөв 2556022.8 мянган төгрөгөөр баталжээ.

Нийт зардлын 1370754.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 42560.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 62279.5 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 861094.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 63333.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 1000.0 мянга, урьд оны үлдэгдлээс 155000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэг, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч 2331.5 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг дутуу авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 342.0 мянган төгрөгийг дутуу авсан байна.

*Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| № | Байгууллагын нэр | Төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Төвлөрүүлэх шилжүүлэг | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Орон нутгийн төсөвт | Улсын төсөвт | |
| 1 | Эрдэнэцогт сумын ЗДТГ | 444,284.7 | 429,854.4 | 14,430.4 | 14,430.4 | | 96.8 |
| 2 | Эрдэнэцогт сумын ИТХ | 87,799.5 | 87,673.8 | 125.7 | 125.7 | | 99.9 |
| 3 | Эрдэнэцогт сумын Ерөнхий боловс | 841,195.2 | 773,667.7 | 67,527.5 | 590.4 | 66,937.1 | 92.0 |
| 5 | Эрдэнэцогт сумын Цэцэрлэг | 275,282.1 | 267,536.7 | 7,745.4 | 4,145.6 | 3,599.8 | 97.2 |
| 6 | Эрдэнэцогт сумын Хүн эмнэлэг | 446,393.8 | 434,758.7 | 11,635.1 | 1,385.8 | 9,907.3 | 97.4 |
| 7 | Эрдэнэцогт сумын Соёлын төв | 180,454.6 | 177,753.5 | 2,701.1 | 2,701.1 | | 98.5 |
| 8 | Эрдэнэцогт сумын ОНХС | 187,279.5 | 172,253.7 | 15,025.8 | | | 92.0 |
| 9 | Эрдэнэцогт сумын СХС | 93,333.4 | 48,053.6 | 45,279.9 | | | 51.5 |
| | Дүн | 2,556,022.8 | 2,391,551.9 | 164,470.9 | 23,379.0 | 80,444.2 | 93.6 |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2391551.9 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь Засаг даргын Тамгын газрын зардлыг 14430.4 мянга, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын урсгал зардлыг 7745.4 мянга, ерөнхий боловсролын сургуулиудын урсгал зардлыг 67527.5 мянга, ИТХ-ын зардлыг 125.7 мянга, Эрүүл мэндийн төвийн зардлыг 11635.1 мянга, Соёлын төвийн зардлыг 2701.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 16. Эрдэнэцогт сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,556,022.8** | **2,391,551.9** | **164,470.9** | **93.6** |
| **70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага** | **87,799.5** | **87,673.8** | **125.7** | **99.9** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 71,068.7 | 70,943.0 | 125.7 | 99.8 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 900.0 | 900.0 | - | 100.0 |
| 80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал | 15,830.8 | 15,830.8 | - | 100.0 |
| **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага** | **444,284.7** | **429,854.4** | **14,430.4** | **96.8** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 308,997.3 | 297,389.7 | 11,607.6 | 96.2 |
| 80106 Баг, хорооны ҮАЗардал | 75,407.9 | 73,181.3 | 2,226.6 | 97.0 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 40,879.5 | 40,297.5 | 582.0 | 98.6 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 19,000.0 | 18,985.8 | 14.2 | 99.9 |
| **70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт** | **187,279.5** | **172,253.7** | **15,025.8** | **92.0** |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 187,279.5 | 172,253.7 | 15,025.8 | 92.0 |
| **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **446,393.8** | **434,758.7** | **11,635.1** | **97.4** |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 31,930.9 | 30,545.1 | 1,385.8 | 95.7 |
| 80302 Нэг иргэнд ногдох нормативаар | 30,704.9 | 30,628.4 | 76.5 | 99.8 |
| 81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлч | 383,758.0 | 373,585.3 | 10,172.7 | 97.3 |
| **71702 Соёл урлаг** | **180,454.6** | **177,753.5** | **2,701.1** | **98.5** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 179,830.6 | 177,482.7 | 2,347.9 | 98.7 |
| 80214 Уран бүтээл хийлгэх | 492.9 | 140.0 | 352.9 | 28.4 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 131.1 | 130.8 | 0.3 | 99.8 |
| **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **275,282.1** | **267,536.7** | **7,745.4** | **97.2** |
| 80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, ү | 4,202.4 | 666.2 | 3,536.2 | 15.9 |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 23,611.5 | 19,465.9 | 4,145.6 | 82.4 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 104.6 | 104.0 | 0.6 | 99.4 |
| 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 14,853.0 | 14,852.9 | 0.1 | 100.0 |
| 81834 Боловсролын стандарт, сургалты | 194,285.8 | 194,248.7 | 37.1 | 100.0 |
| 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 38,224.8 | 38,199.0 | 25.8 | 99.9 |
| **71802 Ерөнхий боловсрол** | **829,316.4** | **761,914.0** | **67,402.4** | **91.9** |
| 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 94,013.7 | 93,423.3 | 590.4 | 99.4 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1,438.5 | 1,420.0 | 18.5 | 98.7 |
| 81801 үдийн цай хөтөлбөр | 23,279.0 | 9,039.2 | 14,239.8 | 38.8 |
| 81806 Дотуур байрны үйлчилгээ | 114,234.5 | 78,208.1 | 36,026.4 | 68.5 |
| 81834 Боловсролын стандарт, сургалты | 442,876.5 | 432,220.2 | 10,656.3 | 97.6 |
| 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 153,474.2 | 147,603.4 | 5,870.8 | 96.2 |
| **71806 Насан туршын болон албан бус боловсрол** | **11,878.8** | **11,753.7** | **125.1** | **98.9** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 11,878.8 | 11,753.7 | 125.1 | 98.9 |
| **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **93,333.4** | **48,053.6** | **45,279.9** | **51.5** |
| 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 93,333.4 | 48,053.6 | 45,279.9 | 51.5 |

*Эх сурвалж: Эрдэнэцогт сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1 байгууллага 12000.0, дээд шатны төсвийн захирагчаас 3 байгууллага 73028.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 5 байгууллага 21556.5 мянга, нийт 106584.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

*Хүснэгт 17. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ЗДТГ | ЕБС | Цэцэрлэг | ЭМТ | Соёл | ИТХ | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нийт нэмэлт санхүүжилтийн орлого | 24,717.1 | 51,140.8 | 5,951.1 | 24,007.9 | 638.0 | 130.0 | 106,584.9 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,000.0 | | | | | | 12,000.0 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 49,089.9 | 5,951.1 | 17,987.4 | | | 73,028.4 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,717.1 | 2,050.9 | | 6,020.5 | 638.0 | 130.0 | 21,556.5 |
| НИЙТ ЗАРЛАГА | 23,271.4 | 36,006.3 | 5,951.1 | 22,667.4 | 627.6 | - | 88,523.8 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 23,271.4 | 36,006.3 | 5,951.1 | 6,504.4 | 627.6 | | 72,360.8 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | | | | | - |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | | 16,163.0 | | | 16,163.0 |
| ТӨВЛӨРҮҮЛСЭН | 1,445.7 | 15,134.5 | - | 1,340.5 | 10.4 | 130.0 | 18,061.1 |

## 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*Хүснэгт 17. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | хугацаа | төрөл | удаа | хугацаанд нь мэдээлсэн | хугацаа хоцроосон | хоцроосон мэдээлэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 12 | 12 | 12 | - | |
| 2 | Хагас жил | 3 | 3 | 3 | - | |
| 3 | Улирал бүр | 2 | 8 | 8 | - | |
| 4 | Сар бүр | 5 | 60 | 57 | 3 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө,гүйцэтгэл-12-р сар, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-12-р сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл-12-р сар, |
| 5 | Тухай бүр | 6 | 72 | 63 | 9 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт-8-р сар,Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл -12-р сар, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл-12-р сар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл-8-р сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг-8-р сар, тушаал шийдвэртэй холбоотой-7,8 сар, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт-8-р сар, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн -8-р сар |
| | Нийт | 28 | 155 | 143 | 12 | |

*Эх сурвалж. Эрдэнэцогт сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас*

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй ба 11800.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

## 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 санхүүгийн тайланд түүвэрт хамруулан иргэдийн төлөөлөгчдийн санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт, 1 байгууллагад "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

*Хүснэгт 19. Хязгаарлалтай дүгнэлт авсан байгууллага*

| БАЙГУУЛЛАГЫН НЭР | ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ |
|---|---|
| **"ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"** | |
| **ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР** | Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газар нь Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57600.0 мянган төгрөгийн үнэ бүхий дизель мотор биетээр байхгүй тооллогоор дутсан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамжаар тус дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон ч захирамжийн хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. |

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар нийт 142564.0 мянган төгрөгийн 19 алдаа, зөрчил илэрснээс 4418.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1149.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 67104.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 69893.0 мянган төгрөгийн 12 зөрчилд менежментийн захидлаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгчээ.

Эрдэнэцогт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 191132.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулж, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 3 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

*<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга</u>*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд ИТХ-ын 3040.0 мянган төгрөгийн бараа материалыг э-тайлангаас зөрүүтэй тусгасан, мөн эрүүл мэндийн төвийн ажиллагсадтай холбоотой 1898.9 мянган төгрөгийн өглөгийг бусад өглөгийн хэсэгт тайлагнасан байна.
- Тайлант оны нэгтгэсэн үр дүнгийн тайланд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үр дүнгийн тайлангийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал болох 36006.3 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг рүү тайлагнасан, мөн ЗДТГ-ын НДШ-ийн 9761.7 мянган төгрөгийн зардлыг зардлын ангилал бүрээр тусад нь тайлагнаагүй, Соёлын төвийн НДШ-ийн 2470.5 мянган төгрөгийн зардлыг ангилал бүрээр тайлагнаагүй байна.

- Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд сургуулийн 8519.8, цэцэрлэгийн 4994.9 мянга, ЗДТГ 29537.5 мянга, ИТХ 2000.0 мянга, Эрүүл мэндийн төвийн 11934.5 мянга, Соёлын төвийн 7454.3 мянган төгрөгийн хөрөнгийн тохируулах бичилтийг хийгээгүй байна.
- Сумын Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн дэмжлэг 860094.9 мянга, төвлөрүүлэх шилжүүлэг 23379.0 мянган төгрөгийг устгах бичилт хийгдээгүй байсныг санхүүгийн тайланд залруулсан.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар аудитлагдсан тайлангийн 2020 оны эцсийн үлдэгдлийг Э-тайлангийн 2021 оны эхний үлдэгдлээр зөв оруулсан эсэхийг нягталж тодруулах шаардлагатай мөн нягтлан бодогч нарын хариуцлагыг дээшлүүлэн санхүүгийн программын эцсийн үлдэгдлийг э-тайлангийн үлдэгдлээр зөв хаалт хийсэн эсэх дээр санхүүгийн албаны дарга хянаж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр байгууллагад мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан " Эдийн засгийн ангилал батлах" тухай журмыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 **Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална" гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.3.1. **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангийн нийт 126082,3 мянган төгрөгийн авлагын–4947.9 мянган төгрөг нь 4 жилийн насжилттай, 50135.1 мянган төгрөг нь 5 буюу түүнээс дээш жилийн насжилттай авлага байна. Мөн Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 63333.4 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 49492.3 мянган төгрөгийн орлогыг оруулж, орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна..

3.3.2. **Эрсдэл:**Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох, авлага найдваргүй болох, орлогын төлөвлөгөө тасрах.

3.3.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 5-с дээш жилийн насжилттай 50135.1 мянган төгрөгийн насжилттай авлагыг барагдуулж, орлого төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3.3.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ 2021.03.25

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.03.25

6417143544
БОА0067 9007423

# 5. Хавсралт 1: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Эрдэнэцогт сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/10/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Эрдэнэцогт сумын Засаг дарга | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд ИТХ-ын 3040.0 мянган төгрөгийн бараа материалыг э-тайлангаас зөрүүтэй тусгасан, мөн эрүүл мэндийн төвийн ажиллагсадтай холбоотой 1898.9 мянган төгрөгийн өглөгийг бусад өглөгийн хэсэгт тайлагнасан байна | 4938.9 | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 2 | Тайлант оны нэгтгэсэн үр дүнгийн тайланд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үр дүнгийн тайлангийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал болох 36006.3 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг рүү тайлагнасан, мөн ЗДТГ-ын НДШ-ийн 9761.7 мянган төгрөгийн зардлыг зардлын ангилал бүрээр тусад нь тайлагнаагүй, Соёлын төвийн НДШ-ийн 2470.5 мянган төгрөгийн зардлыг ангилал бүрээр тайлагнаагүй байна. | 48238.5 | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 3 | Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд сургуулийн 8519.8, цэцэрлэгийн 4994.9 мянга, ЗДТГ 29537.5 мянга, ИТХ 2000.0 мянга, Эрүүл мэндийн төвийн 11934.5 мянга, Соёлын төвийн 7454.3 мянган төгрөгийн хөрөнгийн тохируулах бичилтийг хийгээгүй байна | 64441.0 | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 4 | Сумын Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн дэмжлэг 860094.9 мянга, төвлөрүүлэх шилжүүлэг 23379.0 мянган төгрөгийг устгах бичилт хийгдээгүй байсныг санхүүгийн тайланд залруулсан. | 23379.0 | Санхүүгийн тайланд залруулсан. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 5 | Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайланд хөрөнгө материал, орлого, зарлагын төрлийг зөрүүтэй тайлагнасан, харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагууд нь хөрөнгө материалыг аваагүй байхад тодотгол хийж хөрөнгө бэлтгэхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна. | 0 | Зөвлөмж өгсөн. | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 6 | Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 0 | Зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| 7 | Сум хөгжүүлэх сангийн нийт 126082,3 мянган төгрөгийн авлагын 4947.9 мянган төгрөг нь 4 жилийн насжилттай, 50135.1 мянган төгрөг нь 5 | 50135.1 | Зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, санхүүгийн | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | буюу түүнээс дээш жилийн насжилттай авлага байна. | | | албаны дарга3 | |
| [illegible] | | [illegible]32.6 | | | |
| Харьяа төсвийн байгууллагуудын дүн | | 42564.0 | | | |
| [illegible] | | [illegible] | | | |
| 1 | Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ Тулга Техник ХХК-д шилжүүлээд авлагаар бүртгэсэн. | **1520.0** | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, С.Байгальмаа |
| 2 | Цалин, НДШ-ийн тооцооллыг анхан шатны баримтаар түүвэрлэхэд 1078,1 мянган төгрөгийн цалингийн зөрүүг тооцож суутгаснаа санхүүгийн тайланд цалингийн өглөгөөр тайлагнасан | **1078.1** | Санхүүгийн тайланд залруулсан | Эрхлэгч, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, С.Байгальмаа |
| 3 | Шилэн дансны хуулийн дагуу 27 төрлийн 151 төрлийн мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | **0** | Зөвлөмж өгсөн | Эрхлэгч, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, С.Байгальмаа |
| 4 | Бусад хангамжийн бараа материал дансанд 5 нэр төрлийн 3340,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн. | **3340.0** | Санхүүгийн тайланд залруулсан | Эрхлэгч, нягтлан бодогч | Ж.Содномчимэг, С.Байгальмаа |
| [illegible] | | [illegible] | | | |
| **5** | СХС-гийн тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллээс хугацаандаа оруулсан 12 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 49792.3 мянган төгрөгийн 1 мэдээлэл байна. | **0** | Зөвлөмж өгсөн | Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга3 | С.Цэвэгдорж, Ц.Мөнхбаатар |
| Сургууль | | 21412.0 | | | |
| 6 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан 12 дугаар сарын 49089.9 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 9,12 дугаар саруудад121588.0 мянган төгрөгийн 8 гүйлгээ, нийт 170677.9 мянган төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй байна. | 0 | Албан шаардлага | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| 7 | Сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтан нарт 1,2,4-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 60%-аар бодож 626.9 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 626.9 | Төлбөрийн акт | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| 8 | “Дэвших болор” ХХК -руу сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885,0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийг тайлант онд хүлээж аваагүй байж, үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэж, тооллогын тайланд биетээр байгаагаар тоолсон байна. | 9885.0 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| 9 | Хүүхдийн хоолны зардлыг багшийн ирцийн бүртгэлийн дэвтэр болон харилцагч байгууллагын анхан шатны баримт нярвын орлого зарлагатай тулган шалгахад дотуур байрны хүүхдийн хоол хүнсний зардлаас 5 сард зарцуулсан 2800.9 мянган төгрөгийн анхан шатны баримт, зарцуулалтын тайлан байхгүй, мөн бараа материалын тайлангийн бусад хангамжийн материалын дансанд үдийн цайны хүнсний материалын бүртгэсэн байна. | 2800.9 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| 10 | Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад бүх гүйлгээг анхан шатны баримтаас хөөн шалгахад е-баримтгүй 7137.1 төгрөгийн 3 | 7889.1 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | гүйлгээ, анхан шатны баримтгүй 752.0 төгрөгийн 2 гүйлгээ байна. | | | | |
| 11 | Тайлант хугацааны нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээг тулган шалгахад аймгийн БСУГ-аас тус байгууллагын ажилтанд 13073.9 мянган төгрөгийн өндөр насны тэтгэмжийг олгохоор төсөв батлагдсан ч уг иргэн 1967 онд төрсөн 3 хүүхэдтэй тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох эрх үүсээгүйгээс тэтгэмжийг олгоогүй Төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна. | 0 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| 12 | Цалингийн тооцооллыг давтан тооцоолоход нийгмийн даатгалын үлдэгдэл 7028.3 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд 7238,4 мянган төгрөгөөр өглөг үүсгэж 210.1 мянган төгрөгөөр илүү тусгасан байна. | 210.1 | Зөвлөмж | Захирал, нягтлан бодогч | С.Дагвадорж, М.Мягмарсүрэн |
| Засаг даргын Тамгын газар | | 105187.5 | | | |
| 13 | Тус байгууллын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57600.0 мянган төгрөгийн үнэ бүхий дизель мотор биетээр байхгүй тооллогоор дутсан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамжаар тус дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон ч захирамжийн хэрэгжүүлээгүй байна. | **57600.0** | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 14 | Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 8290.0 мянган төгрөгийг цаг үеийн байдалтай холбогдуулан зориулалт бусаар зарцуулсан байна. | **8290.0** | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 15 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл санхүүгийн тайланд 197148.6 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 197374.6 мянган төгрөгөөр буюу 226.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна. | **0** | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| 16 | Тус байгууллагын төсвийн төсөлд тусгаагүй боловч 2020 оны төсөвт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 39297.5 мянган төгрөг батлагдсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 7-р тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг зөрчин ажлаас чөлөөлөх тушаал шийдвэр гараагүй байхад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 39297.5 мянган төгрөг олгож авлага үүсгэсэн байна. | 39297.5 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | Р.Болормаа, М.Мягмарсүрэн |
| Эрүүл мэндийн төв | | 10026.4 | | | |
| 17 | Тус байгууллагын 3 ажилтны 2-р улирлын үр дүнгийн урамшууллын нийт 522180 төгрөгийн цалинг НДХ-т мэдээлээгүй, түүнд ногдох 125323 төгрөгийн шимтгэлийг нийгмийн даатгалд мэдээлээгүй өглөгт тусгасан. | 522.2 | Төлбөрийн акт тогтоов | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгальмаа |
| 18 | Тусгай зориулалттай бараа материал дансанд 20035,5 мянган төгрөгийн, аж ахуйн материал дансанд 7397,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдээд 3-7 жил болсон байна. Хөрөнгүүдийг цаашид ашиглах жилээр ангилахад 17929,2 мянган төгрөгийн эмнэлгийн зориулалттай тоног төхөөрөмжийн элэгдлийн хугацаа дууссан, 9504,2 мянган төгрөгийн хөрөнгө тавилга, эд хогшил бүртгэгдсэн байгаад | 9504.2 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгальмаа |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | байгууллагын өмч хамгаалах зөвлөл анхаарч ажиллаагүй байна. | | | | |
| 19 | Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын тооцоог ЕЖ-аас харилцагч бүрээр түүвэрлэн тулгалт хийхэд Илдэн гүн хошуу ХХК-аас 2688,5 мянган төгрөгийн "элэг бүтэн" хөтөлбөрийн хүрээнд оношлуур худалдан авч, төсвөөс 1751,0 мянган төгрөгийг шилжүүлж, оны эцэст 937,5 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ. Монос Баянхонгор ХХК-аас 19282,1 мянган төгрөгийн эм, боох материал худалдан авч 6558,5 мянган төгрөг шилжүүлсэн 12723,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Санхүүгийн тайлангаар нийт 15569.4 мянган төгрөгийн өглөгтэй байна. | 0 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | С.Батням, С.Байгальмаа |

___________oOo_________